

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2010 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн нийт орлогын бүрдүүлэлт 119.1 хувийн, нийт зарлага 84.9 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт алдагдал 167.5 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 449.7 тэрбум төгрөгөөр бага байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

**А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:**

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2010 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 1,239.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 199.1 тэрбум төгрөгөөр буюу 19.1 хувиар давж биелж, 2009 оны мөн үеийнхээс 50.0 хувиар буюу 413.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:**

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	2010 ОНЫ 6-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
	(Тэрбум төгрөг)						
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>826.3</b>	<b>2,427.0</b>	<b>1,040.5</b>	<b>1,239.6</b>	<b>119.1</b>	<b>51.1</b>	<b>199.1</b>
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>824.9</b>	<b>2,403.4</b>	<b>1,031.6</b>	<b>1,205.6</b>	<b>116.9</b>	<b>50.2</b>	<b>174.0</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>646.0</b>	<b>2,083.7</b>	<b>895.7</b>	<b>1,073.6</b>	<b>119.9</b>	<b>51.5</b>	<b>177.9</b>
Орлогын албан татвар	164.3	698.6	291.4	355.0	121.8	50.8	63.6
ААН-ийн орлогын албан татвар	74.3	268.8	98.0	157.0	160.2	58.4	59.0
Хувь үний орлогын албан татвар	58.7	119.2	60.2	67.0	111.2	56.2	6.8
Зарим ҮТЭГДЭХҮҮНИЙ үнийн өсөлтийн татвар	31.3	310.6	133.2	131.0	98.4	42.2	-2.2
<b>Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж</b>	<b>117.8</b>	<b>278.6</b>	<b>128.8</b>	<b>145.2</b>	<b>112.7</b>	<b>52.1</b>	<b>16.4</b>
Өмчийн татвар	5.1	10.5	5.1	5.8	113.9	55.4	0.7
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	233.9	696.0	308.6	361.9	117.2	52.0	53.2
Гадаад худалдааны орлого	54.6	153.1	65.8	78.5	119.3	51.2	12.7
Бусад татвар	70.3	246.8	96.0	127.3	132.6	51.6	31.3
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>178.9</b>	<b>319.7</b>	<b>135.9</b>	<b>132.0</b>	<b>97.1</b>	<b>41.3</b>	<b>-3.9</b>
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>1.4</b>	<b>1.6</b>	<b>1.9</b>	<b>2.1</b>	<b>113.0</b>	<b>132.7</b>	<b>0.2</b>
<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>22.0</b>	<b>7.1</b>	<b>31.9</b>	<b>0.0</b>	<b>145.0</b>	<b>24.9</b>

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлог о татварын орлогоор 86.6 хувь, татварын бус орлогоор 10.7 хувь, тусламжийн орлогоор 2.6 хувь, хөрөнгийн орлогоор 0.2 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна.

Дэлхийн зах зээл дэх зэс, алтны үнэ төлөвлөсөн хэмжээнээс харьцангуй тогтвортой өндөр байсан, Татварын өрний газраас аж ахуйн нэгжүүдийн татварын өр барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулсан, татвартай барааны импортмөнх оноос 65.5 хувиар өссөн, АНУ-ын санхүү, эдийн засгийн хямралтай байгаа орнуудад үзүүлж буй тусламжийн хүрээнд манай улсад 14.5 тэрбум төгрөгийн мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн санхүүжилтэд зориулан олгосон зэрэг нь нэгдсэн төсвийн орлого төлөвлөгөөнөөс давж биелэхэд нөлөөлсөн байна.

**Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:**

ӨСВИЙН ОРЛОГО	Улсын өсөв		Орон нутгийн өсөв		ХХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.өгрөг )							
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>827.5</b>	<b>978.4</b>	<b>137.5</b>	<b>155.6</b>	<b>30.6</b>	<b>49.6</b>	<b>242.6</b>	<b>256.8</b>
УРСГАЛ ОРЛОГО	740.3	867.1	125.8	143.7	30.6	49.6	166.0	180.2
ТАТВАРЫН ОРЛОГО	620.8	745.8	115.5	133.0	30.6	49.6	166.0	180.2
<b>Орлогын албан татвар</b>	<b>231.2</b>	<b>288.0</b>	<b>60.2</b>	<b>67.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
ААН-ийн орлогын албан татвар	98.0	157.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	60.2	67.0	0.0	0.0	0.0	0.0
Зарим ҮТээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	133.2	131.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>166.0</b>	<b>180.2</b>
<b>Өмчийн татвар</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>5.1</b>	<b>5.8</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	299.9	352.8	8.7	9.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	65.8	78.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	24.0	26.5	41.5	51.1	30.6	49.6	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119.4	121.3	10.3	10.7	0.0	0.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	1.9	2.1	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	87.2	111.3	9.8	9.8	0.0	0.0	76.6	76.6

- Улсын өсвийн орлого 978.4 тэрбум өгрөгт хүрч 18.2 хувиар буюу 150.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давсан байна. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын орлого 60.2 хувиар буюу 59.0 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 25.4 хувиар буюу 49.2 тэрбум, гадаад худалдааны орлого 19.3 хувиар буюу 12.7 тэрбум, тусламжийн орлого 27.6 хувиар буюу 24.1 тэрбум өгрөгөөр тус тус давж биеллээ.
- Орон нутгийн төсвийн орлого 155.6 тэрбум төгрөгт хүрч, 13.2 хувиар буюу 18.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Сэлэнгэ аймаг төсвийн орлогын төлөвлөгөөг 2.6 тэрбум, Орхон аймаг 4.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлтэй шууд холбоотой байна. Нийслэлийн өмчийн татварын орлого 0.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн хэдий ч хувь хүний орлогын албан татварын орлого 4.9 тэрбум, газрын төлбөрийн орлого 0.8 тэрбум, жү торгуулийн орлого 0.5 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс тус тус давж биелсэн зэргээс нийт орлого 6.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давсан үзүүлэлттэй байна.
- Хүний хөгжлийн санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 49.6 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 62.4 хувиар буюу 19.1 тэрбум төгрөгөөр илүү байна. Харин тус санд Эрдэнэт УҮГ -аас хувьцааны ногдол ашгийн орлого 6.1 тэрбум өгрөг орохоор төвлөсөн өн ч гүйцэтгэлээр төсөвт төвлөрөөгүй байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 256.8 тэрбум төгрөгт хүрч, 5.8 хувиар буюу 14.2 тэрбум өгрөгөөр орлогын төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох төлөвлөсөн 76.6 тэрбум төгрөгийн татаасыг бүрэн санхүүжүүлсэн байна.

**Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:**

Монгол Улсын нэгдсэн өсвийн нийт зарлага 2010 оны эхний хагас жилийн байдлаар 1,657.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 1,407.1 тэрбум төгрөгийн буюу 84.9 хувийн, улсын



**Төсвийн тэнцэл:**

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 104.6 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 167.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 105.7 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 75.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

ОУВСангаас хэрэгжүүлж байгаа “Тогтворжуулах” төлбөрийн хүрээнд төлбөрийн тэнцлийг сайжруулах зорилгоор 25.5 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлжих тусгай эрхийг ОУВСангаас Монголбанк дахь улсын төсвийн харилцах дансанд байршуулсны дагуу улсын төсвөөс Монголбанк дахь ОУВСангийн үнэт цаасны дансанд Монголбанкинд Засгийн газрын үнэт цаас арилжаалах замаар дээрхтэй тэнцэх хэмжээний төгрөгийг байршуулсан.

Тайлант хугацаанд гадаад зээлийг үндсэн төлбөрт 26.9 тэрбум төгрөгийг төлж, 24.1 тэрбум төгрөгийн төслийн зээлийг ашигласан гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсыг өгжүүлэх сангийн 2009 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болох 134.1 тэрбум төгрөгийг улсын төсвийн харилцах дансанд шилжүүлэн 2010 оны улсын төсвийн зарлагын эх үүсвэр болгосон.

-----oOo-----